



Golomt Capital®

БОНДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.06.15

*Засгийн газрын бонд
Компанийн бонд*

БОНДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 6 сарын 15

ЗГ-ийн евро- бондын өгөөж	Үнэ	Хаалтын өгөөж	Сарын эхэнд	Оны эхэнд
	78.500	7.804%	7.051%	5.225%

Товч дүгнэлт:

Өнгөрсөн долоо хоногт засгийн газрын бондын өгөөж 7.8 хувьд, Mongolian Mining Corporation компанийн бондын ханш 68.3 центэд тус тус хүрсэн байна. Харин МХБ-ээр дамжуулан 889 сая төгрөгийн бондын арилжаа хийгдсэн бол биржийн бус зах зээлд 5.6 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдсэн байна.

Засгийн газрын үнэт цаас:

Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж 6 сарын 14-ний өдрийн байдлаар 7.804 хувийн өгөөжтэйгөөр хаагдаад байна. Засгийн газрын бондын өгөөж нь тухайн улс орны эдийн засгийн байдалтай урвуу хамааралтай байдаг.

График 1: 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөж**Бондын хөрөнгө оруулалтад нөлөөлөхүйц үйл явдал, суурь үзүүлэлтүүд:**

- 2022 оны 5 сарын байдлаар Улсын инфляцын түвшин 15.1 хувьд хүрч 2012 оноос хойших хамгийн дээд түвшиндээ хүрлээ. Инфляц өндөр түвшинд хүрснээр ирэх долоо хоногийн баасан гарагт Монголбанк бодлогын хүүг өсгөх дарамт нэмэгдэж байна. Олон Улсын Валютын Сан хилийн хязгаарлалт болон Украины нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсад стагфляц буюу өндөр инфляц болон эдийн засгийн уналт нүүрлэхээр байгааг анхааруулсан юм.
- 2022 оны 3 сарын 24-ний өдөр Монголбанкнаас бодлогын хүүг 2.5 нэгж хувиар өсгөж 9.0 нэгж хувьд хүргэлээ. Олон улсын нөхцөл байдал шокийн шинжтэй нөлөө үзүүлж байгаа нь эрчимтэй шийдвэр гаргахад нөлөөлсөн байна. Бодлогын хүү өссөнөөр банкны эх үүсвэрийн хүү өсөхөөс гадна дотоодын зах зээл дээрх бондын хүү өсөх зүй тогтлыг үзүүлдэг.


Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

КОМПАНИЙН БОНДЫН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гадаадын зах зээл дэх бондын мэдээлэл:

Хонгконгийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй **Mongolian Mining Corporation** компанийн 2024 оны 4 дүгээр сард хугацаа нь дуусах ам.долларын бондын ханш нүүрсний гол худалдан авагч болох БНХАУ хязгаарлалтын арга хэмжээгээ чангатгаад байгаатай холбоотойгоор 3 дугаар сарын 25-наас хойших хамгийн өндөр уналтыг үзүүлээ. Бондын ханш 68.3 цент болж, 9.25 хувиар унасан байна.

График 2: Mongolian Mining Corporation-ы бондын ханш



Дотоодын зах зээл дэх бондын арилжааны мэдээлэл:

Өнгөрсөн долоо хоногт МХБ-ээр дамжуулан нийт 888.7 сая төгрөгийн нээлттэй бонд арилжаалагдлаа. Нээлттэй арилжаалагдаж буй төгрөгийн бондын дундаж хүү 13% байгаа бол ам.долларын бондын дундаж хүү 6.8% байна.

Хүснэгт 1: Бондын арилжааны мэдээлэл

Бондын нэр	Тоо ширхэг	Үнийн дүн	Хүүгийн хэмжээ
ЭТТ ам.долларын бонд	2	90,000	6.8%
ЭТТ төгрөгийн бонд	1	499,250,000	10.0%
Инвектор ББСБ ХК-ийн бонд	5,614	108,062,460	13.0%
Лэнд МН бонд 1	478	617,871	14.0%
Лэнд МН бонд 2	18	1,784,000	15.0%
Нийт /төгрөгийн/	6,113	888,714,331	13.0%

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Биржийн бус зах зээлийн өгөөжийн муруй:

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хүү үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хүү болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 3 : Биржийн бус зах зээлийн өгөөжийн муруй



Биржийн бус зах зээлийн долоо хоногийн арилжааны тойм:

Биржийн бус зах зээлд өрийн хэрэгслийн нийт 28,466 ширхэг үнэт цаас **5.6 тэрбум төгрөг**, 68 ширхэг үнэт цаас **6,983.60 ам.доллараар** тус тус арилжаалагдсан. Үүнээс анхдагч зах зээлд 21,500 ширхэг үнэт цаас арилжаалагдаж **3.5 тэрбум** төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ.

Биржийн бус зах зээлд амжилттай хаагдсан бондууд:

Мони Маркет Бонд



2.0 тэрбум ₮

Таванбогд Финанс Бонд



1.0 тэрбум ₮

Бичил Глобус Бонд



500 сая ₮

ОНЦЛОХ БОНД:

Энэ удаагийн дугаарт хамгийн богино хугацаатай бонд болох Мони Маркет Фанд ХХК-ийн 4 долоо хоног, 12 долоо хоногийн хугацаатай бондуудыг онцоллоо. Бондын нөхцөл:

- 4 долоо хоног – жилийн хүү 10.2%
- 12 долоо хоног – жилийн хүү 12.6%

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Бэлтгэсэн:



Р.Дарханбаяр

Хөрөнгө оруулалтын шинжээч

Darkhanbayar@golomtcapital.com

+976 9490 4321

Golomt Capital[®]

7012-1530
info@golomtcapital.com
www.golomtcapital.com